

ТЭТГЭВЭР АВАХ ДУНДАЖ ХУГАЦААНЫ ИЛЭРХИЙЛЭЛ ТОГТООХ ТУХАЙ

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 01/957 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй.
- 2.Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр бодоход баримтлахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт)-т даалгасугай.
3. Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тооцох аргачлалыг Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн боловсруулж батлуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т даалгасугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч) -нд үүрэг болгосугай.

ДАРГА А.АРИУНЗАЯА